



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/125

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17.1, 19.21 дэх заалтууд, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон Булган сумдын нэгдсэн эмнэлэг, Алтай, Буянт, Дарви, Ховд, Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвүүд, Алтай, Буянт, Дөргөн, Мөнххайрхан, Мянгад, Зэрэг, Цэцэг сумдын эмийн эргэлтийн сангууд, Ачит-Алтан хундага эмийн сан, Бүрэн дүүрэн эмийн сан, Гурван-Эрдэнэ хүүхдийн эмнэлэг, Ховд мед эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг, Ариун шүд шүдний эмнэлэг, Зэвсэгт хүчний 0123 дугаар ангийн эмнэлгийн үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жилээр, “Түмний ачит тунгалаг” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жилээр тус тус сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон хордлого тайлах, дархлаа дэмжих, өдрийн эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх “Скай мед” эмнэлэгт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр олгож, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай Үенч сумын эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатайгаар түр түдгэлзүүлсүгэй.

3.Эмэгтэйчүүдийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө үзүүлэх “Эх-Үр” эмнэлгийн тусгай зөвшөөрлийн эрхийг эмэгтэйчүүдийн их эмч П.Улаанхүүгийн нэр дээр

Zax A/125 Ch

02 0354

шилжүүлэх, мэдрэлийн өвчний оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө үзүүлэх зөвшөөрөл бүхий Очир сүлд эмнэлэгт 3 ор нэмж олгох, элэгний архаг үрэвсэлт өвчин, гельминтоз өвчний оношилгоо эмчилгээ, зөвлөгөө үзүүлэх зөвшөөрөл бүхий “Элэг-Энэрэл” эмнэлэгт халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө үзүүлэх тусламжийн чиглэлийг нэмж, тусгай зөвшөөрлийн эрхийг халдвартын их эмч Н.Гантуулын нэр дээр шилжүүлэх нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус оруулсугай.

4.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон, сунгасан, нэмэлт өөрчлөлт оруулсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ